



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 9/198

Улаанбаатар хот

Согтууруулах ундаа худалдах, түүгээр
үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.8, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30.1, 30.2 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/847, 2024 оны А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/244 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн 2025 оны 07 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл шинээр олгох 5 хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох 3 хуулийн этгээдийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгогдсон хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (М.Навчаа), Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар (Ц.Амгалан-Энх), дүүргийн 1-24 дүгээр хорооны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.


3. Үнэт цаасны бичилт, олголт, хураамжид байнгын хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхбаяр), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ


1525010594



Чингэлтэй дүүргийн Засаг даргын
2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ШИНЭЭР ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Хуулийн этгээдийн нэр	Захирал	Оноосон нэр	Хуулийн этгээдийн регистр	Ангилал	Төрөл	Хороо	Хаяг, байршил
1	Оч Зам ХХК	Б.Цасцэцэг	Оч	5754348	Хүнсний дэлгүүр	06:00-00:00	16	Согоотын 50-579 тоот
2	Премиум Нэксус ХК	А.Ганхуяг	Си Юү 56	6155804	Ая тухтай дэлгүүр	24 цаг	1	Бага Тойруу 3/9-байр 1 давхарт
3	Премиум Нэксус ХК	А.Ганхуяг	Си Юү 107	6155804	Ая тухтай дэлгүүр	07:00-00:00	1	40 мянгат 5-р байр 1 тоот
4	Премиум Нэксус ХК	А.Ганхуяг	Си Юү 226	6155804	Ая тухтай дэлгүүр	24 цаг	24	Шадивлан 6-661 тоот
5	Мөнх Жаргалант Баялаг ХХК	Э.Алтанцэцэг	Гурван Эрдэнэ	6296114	Хүнсний дэлгүүр	06:00-00:00	17	Зүрх Уулын 1-541 тоот



Чингэлтэй дүүргийн Засаг даргын
2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ШИНЭЭР ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Хуулийн этгээдийн нэр	Захирал	Оноосон нэр	Хуулийн этгээдийн регистр	Ангилал	Төрөл	Хороо	Хаяг, байршил
1	Индивидуал Рестаурант ХХК	Т.Билгүүн	Дорчестер	6632637	Ресторан	11:00-04:00	1	Бодь цамхаг 2 давхар
2	Эндаумэнт ХХК	Э.Хишигсүрэн	World lounge	6920136	Баар/Кароаке	14:00-04:00	2	19-р байр 903 тоот
3	Новодоорс ХХК	Дулэнг	Эзэн шөл	5667151	Ресторан	11:00-04:00	4	Баруун сэлбэ гудамж 53/1 тоот